


БҮРТГЭСЭН ХАНДАЛТ 509↓ (сүвгаар)

УТСААР
375↓

73.7%

26.3%



Суваг	2024	2025
	09.01	
	393	375
	14	21
	6	34
	38	44
	17	18
	25	17
#	493	509


Нийт дуудлага
1093↓

Хүлээн авсан дуудлага
375↓

Дуудлага авсан
36.5%↑

eMongolia-д шилжүүлсэн – 65↓
Алдсан дуудлага – 653↓

ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН БАЙГУУЛЛАГА



ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ



ӨНӨӨДРИЙН ОНЦЛОХ 3 АСУУДАЛ

ОНЦЛОХ АСУУДАЛ-1

ХСҮТ-ийн авто машины зогсоолд зогсоход эхний 15 минутад 1500 төгрөгийг төлж байна. Хүнд өвчтэй хүн зөөх болон эргэлтээр ороход хүндрэлтэй байна. Төрийн байгууллага, тэр тусмаа эмнэлэгийн байгууллага яагаад автомашины зогсоолын төлбөр авч байгаа вэ. Заавал авах шаардлагатай бол эхний 30 минутаас дээш гарсан төлбөрийг авч байх зохицуулалтыг хийх талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-2

БЗД-27, Ерөнхий боловсролын 127-р сургуулийн 11-р ангид суралцдаг юм. Анги даасан багш нь жирэмсний амралтаа авсан. Гэтэл сургуулийн захиргаанаас эцэг, эхээс нь ямар ч зөвшөөрлийг авалгүйгээр дур мэдэн ангийг тараасан байгаад гомдолтой байна. Сургуулийн удирдлагад хандахад "Сургуулийн дотоод журам" гээд хүлээн авахгүй байгаа болно. Иймд эцэг, эхчүүд уг асуудлыг эсэргүүцэж байгаа тул яаралтай холбогдох газар нь арга хэмжээг авч ажиллах талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-3

Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд "Инперо майнинг" ХХК нь алт ухаад өөрсдийн газраас давж малын бэлчээр, байгаль орчинг сүйтгээд, сэндийчээд бохирдуулж байгааг яаралтай шалгаж арга хэмжээг авч өгөхийг хүсэж байна. Иргэд удаа дараа аймагтаа хандсан боловч асуудлыг шийдэж өгөхгүй байгаа талаар

ШИЙДВЭРЛЭЛТ:

311↓

ХАРИЛЦАХ ТӨВ
11:11

ХАРИЛЦАХ ТӨВ
11:11

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

- ✓ **СБД-ийн Улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч н.Энхцацрал, н.Баяржаргал нарт маш их талархаж байна. Байгууллагын баримт бичгийг солих, нэрийн хайлт хийх, баталгаажуулалт, бүрдүүлэлт зэрэг ажлаар нэг цэгийн үйлчилгээн дээр очиход мэргэжлийн арга зүйгээр хангаж, иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлсэн ба асуудлыг зөв нухацтай, ойлгомжтой тайлбарлаж, сэтгэлээсээ ажлаа хийж байгаа зэрэг нь мэргэжлийн өндөр ур чадвартай, ажилдаа эзэн болсон, сайтар бэлтгэгдсэн төрийн албан хаагч юм гэсэн сэтгэгдлийг төрүүллээ. Та бүхний гэгээн үйлс дэлгэрч, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсье. Хүндэтгэсэн "Баян дүүрэн дөрөлж" ХХК-ийн хамт олноос**
- Үйлдвэр ААН-үүдийг ус цэвэршүүлэх байгууламжтай болгох тушаал шийдвэр гаргасан байна. Ус сувгийн бохирдол бууруулах нэгж газарт албан тоотыг нэг цэгийн үйлчилгээгээр болон Монгол шуудангаар дамжуулан өгөх боломжтой гэж хэлээд биеэр өгсөн ч хүлээж авахгүй байна. Албан бичгийн шийдвэрлэх хугацааг богиносгох зорилгоор түргэн шуурхай шийдвэрлэхийг хүсэж байгууллагын ажилтанг авдаг болгох хүсэлтэй байна. Уг хүсэлтийг УСУГ-т уламжилж өгнө үү.

ХҮТ – ОРОН СУУЦ, НИЙТИЙН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- БЗД-ийн Амгалан хотхоны Өөдөө байгаль гээд контор нь ажлаа огт хийхгүй байна. Хотхоны 14, 12, 15-р байрууд нь өмхий үнэртсэн ус алдсан байдалтай байгаад 1 жил гаруй болж байна. Сүүлдээ мөөгөнцөр хөгц үүсээд асуудалтай болсон. Яагаад энэ асуудал дээр анхаарч арга хэмжээ авахгүй байна вэ? Тогтмол арчлалт засварыг тухайн байгууллага хариуцах ёстой шүү дээ. Холбогдох газар нь уламжилж өгнө үү.
- СБД-9, 78,80-р байрны халуун ус жил бүрд гадна шугам гэмтэлтэй гэдэг шалтгаанаар хаасаар өдийг хүрлээ. Өвөл ч байнга доголдолтой дуудлага чирэгдэл болж байж тавьдаг. Харьяалагдах ОСНААҮ-гийн ХҮТ-5 асуудал тавихаар "Зүүн түгээх, дулааны шугам сүлжээ" ХК засварлах ёстой, манайх дотор шугамаа хариуцдаг гэж тайлбарладаг. Зүүн түгээх нь "Эрчим хүчний зохицуулах хороо шийдэж өгнө" гэж дулааны улиралд иргэд оршин суугчдыг хохироосоор байна. Одоо аль байгууллага нь шийдэж өгөх нь тодорхойгүй оршин суугчид хохирч байгаа тул гомдлыг холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.

НИЙГМИЙН ДААТГАЛ

- 2025 оны 06 дугаар сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлтээ гаргасан хэдий ч одоог хүртэл олголт өгөөгүй. ЧД-ийн НДХэлтэс санхүүжилт байхгүй гэсэн шалтгаанаар 08 дугаар сарын эхний олголтыг олгоогүй байна. Ажилгүйдлийн даатгалын санд сар бүр хуримтлуулсан даатгалаасаа тэтгэмжээ авах гэж байгаа шүү дээ. Ажилгүй хугацаандаа авч, санхүүгээ зохицуулах хэрэгсэл гэж цалингаас татвар авдаг биз дээ. Ийм байхад татвар төлж яах вэ. Шийдвэрлээгүй байж асуудлаа шийдвэрлэсэн гэж хааж байгаад гомдолтой байна. Иймд НДЕГ-т гомдлыг уламжилж өгнө үү.
- Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын газраас авах ажилгүйдлийн тэтгэмжийн сүүлийн олголт 06 сарын 15-нд орох ёстой байсан боловч өнөөдрийг хүртэл ороогүй байгаад гомдолтой байна. Өр зээл нэхэгдээд маш хүнд байдалтай байна. Энэ асуудлыг холбогдох дээд газарт нь уламжилж өгнө үү.

ЦАХИЛГААН, ЭРЧИМ ХҮЧ

- МУИС-ийн хойд талын автобусны буудлын явган хүний зам дээр модноос унжиж байгаа цахилгааны утсыг яаралтай аюулгүй болгож засч янзлах хүсэлтийг холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.
- СХД-21, 3-61 Булгийн 16-22 тоот 220В-ийн цахилгаан татуулах хүсэлт өгсөн. Гэтэл газар доогуур татах боломжгүй гээд байгаа юм. Манай урд, хойд хажуу айлууд бүгд газар доогуур татсан байна. Энэ асуудалд гомдолтой байгаа тул холбогдох газар шалган хариуг өгч ажиллана уу.

ЦАЛИН ХӨЛС

- Улаанбаатар ус цаг уур орчны шинжилгээний төвийн ХУД өртөөний дарга холбогдож байна. Манай байгууллага хөдөлмөрийн хуулийг зөрчөөд ажилтнаа илүү цаг ажиллуулж ажиллуулсан хугацааны цалинг олгохгүй байна. Ажилчдын нийт тоо 5 хүн байдаг. 1 хүн ажлаас гарсан 1 хүн гэмтэл аваад өвчтэй байх үед орон тооны хүн авахгүй байгууллага дотроо шийднэ гээд 3 ажилтныг илүү цагаар амралтгүй ажиллуулж байна. Ажилчдын илүү цагийн мөнгийг 04 дүгээр сараас хойш огт олгоогүй. Холбогдох байгууллагад нь уламжлан шийдэж өгнө үү.
- "Богдхан төмөр зам" бүтээн байгуулалтын ажилд 2 сар ажилласан. Гэтэл одоог хүртэл ажилласан хугацааны цалин хөлсийг хөдөлмөрийн хуулиар олгохгүй байгаад гомдолтой байна. Уг асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.